

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг үл хөдлөх хөрөнгийн салбарын болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн бол эрчим хүчний салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

Энэ долоо хоногт S&P 500 индексийн сагсанд багтдаг хувьцаат компаниудын 37% нь 3-р улирлын санхүүгийн тайлангаа нийтэд ил болгов. Энэ оны 3-р улиралд "McDonald's", "Ford Motors" болон "Tesla" компаниудын орлого нэмэгдэж, эдгээр компаниудын хувьцааны ханш өсчээ. Харин "Amazon.com" болон "Alphabet" компаниудын орлогын өсөлт удааширснаар нэгж хувьцааных нь ханш унаж, хөрөнгийн зах зээлийн индекст хүчтэй нөлөөлсөн байна. "FactSet" агентлагийн үзэж байгаагаар S&P 500 индексийн хувьцаат компаниудын нэгдсэн орлогын дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23%-аар өсөх ажээ.

БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх АНУ-ын гаалийн татварын бодлогын нөлөө, Европын бүсийн эдийн засгийн удаашрал, Саудын Арабын сэтгүүлч Жамаль Хашоггийн тодорхойгүй байдлаар амиа алдсан зэрэг асуудал хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ. Саудын Араб газрын тосны гарцаа нэмэх талаар мэдээлж, газрын тосны ханш унасан байна.

АНУ-ын Худалдааны яамын мэдээлснээр 3-р улиралд АНУ-ын эдийн засаг 3.5%-аар өсчээ. Сүүлийн жилүүдэд тус улсын эдийн засаг 2.0-2.5%-аар өсч байсан бол энэ удаад таамаглаж байсан түвшнээс өндөр байлаа. АНУ-ын хэрэглээний түвшин нэмэгдсэн ч, хадгаламжийн түвшин буурсан үзүүлэлттэй байна.

Европ: Итали болон Европын холбооны харилцаа тус улсын төсвийн асуудалтай холбоотойгоор хагарч, Европын компаниудын хувьцааны ханш буусан үзүүлэлттэй байна.

10-р сард Европын бүсийн борлуулалтын менежерүүдийн индекс сүүлийн хоёр жилийн доод түвшинд хүрчээ.

Европын Төв банк бонд худалдан авах хөтөлбөрийг энэ он дуустал хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө хэвээр үлдээсэн байна. Цаашлаад ирэх оны зун дуустал бодлогын хүүг одоогийн түүхэн доод түвшинд хэвээр үлдээнэ гэсэн дохиог зах зээлд өгсөн юм.

"Moody's" агентлаг Итали улсын зээлжих зэрэглэлийн "БааЗ" болгон бууруулж, тус улсын Засгийн газрын бондын өгөөж тогтворжив. Долоо хоногийн эхээр Европын холбоо Италийн 2019 оны төсвийн төслөөс татгалзсан билээ. Энэ нь Европын холбоо анх удаа өөрийн гишүүн орны төсвөөс татгалзаж байгаа юм. Итали улс шинэчилсэн төсвийн төслийг 3 долоо хоногийн дотор Европын холбоонд барих үүрэгтэй билээ. Харин тус улсын эрх баригчид 2019 оны төсвийн төсөлд ямар нэгэн өөрчлөлт оруулах бодолгүй байгаа талаар мэдээлсэн.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индекс уналттай хаагдлаа.

9-р сард Япон улсын хэрэглээний үнийн индекс 1%-д хүрчээ. Энэ нь сүүлийн 7 сарын хугацаанд үзэгдээгүй хурдан өсөлт хэдий ч Төв банкны 2%-ийн зорилтот түвшний талтай тэнцэж байна. Газрын тосны ханш нэмэгдсэн нь инфляцийн түвшинд нөлөөлжээ.

БНХАУ: Юанийн ханш ам.долларын эсрэг сүүлийн 10 жилд үзэгдээгүй доод түвшинд хүрлээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,652.18	0.87% ▲
Dow Jones	АНУ	24,688.31	-2.97% ▼
S&P 500	АНУ	2,658.69	-3.94% ▼
Nasdaq	АНУ	7,167.21	-3.78% ▼
S&P/TSX	Канад	14,888.26	-3.76% ▼
FTSE 100	Их Британи	6,939.56	-1.56% ▼
S&P/ASX 200	Австрали	5,665.20	-4.62% ▼
Nikkei 225	Япон	21,184.60	-5.98% ▼
Hang Seng	Хонг Конг	24,717.63	-3.30% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.44
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	96.03
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	95.44
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.94
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.51
DBM' 2023	USD	7.250%	98.25
TDBM' 2020	USD	9.375%	105.21

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.297	0.01 ▲
Libor 3M	2.520	0.04 ▲
Libor 6M	2.777	0.05 ▲
Libor 1YR	3.057	0.04 ▲
US 6M Bond	2.455	-0.01 ▼
US 2YR Bond	2.806	-0.10 ▼
US 3YR Bond	2.858	-0.12 ▼
US 5YR Bond	2.909	-0.14 ▼
US 10YR Bond	3.077	-0.11 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.10.26	Өөрчлөлт
USD	2,563.94	-0.01% ▼
CNY	369.44	-0.11% ▼
EUR	2,917.12	-0.62% ▼
RUB	39.08	0.23% ▲
KRW	2.25	-0.44% ▼
JPY	22.89	0.35% ▲
CAD	1,951.40	-0.65% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,234.88	0.55% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.72	0.41% ▲
Зэс	USD/lb.	275.15	-1.40% ▼
Нүүрс	USD/MT	108.70	-2.22% ▼
WTI газрын тос	USD/bbl.	67.69	-2.25% ▼
Brent газрын тос	USD/bbl.	77.74	-2.70% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.14	-2.18% ▼

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. IX	5.70%
Бодлогын хүү	2018. IX	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. IX	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. IX	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	17.50%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. IX	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 46 компанийн 806.6 сая төгрөгийн 2,083,993 ширхэг хувьцаа арилжигдав.

“Фронтинер лэнд групп” /MDR/ компанийн хувьцаа 19.05%-аар буюу хамгийн ихээр өсч 250 төгрөгт хүрч хаагдсан бол “Ноёт хайрхан” /NIE/ компанийн хувьцаа 16.36%-аар буурч 501.82 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


10-р сарын 26-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,432.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,652.18 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.87%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	806.6
Зах зээлийн үнэлгээ	2,432,668.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,652.18	0.87% ▲
MSE I индекс	9,862.97	0.68% ▲
MSE II индекс	8,948.58	0.78% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	1,400,895	107,558,371
Ард даатгал	228,366	180,718,771
Айтүүлс	145,805	17,102,326
АПУ	84,133	49,537,211
Монгол базальт	57,382	19,379,723

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Фронтинер лэнд групп	250.00	19.05% ▲
Жуулчин дюти фрий	104,500.00	13.00% ▲
Ариг гал	3,999.00	11.70% ▲
Хөвсгөл алтан дуулга	679.00	8.62% ▲
Гермес центр	156.90	5.30% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ноёт хайрхан	501.82	-16.36% ▼
Дөрвөн-Уул	1,955.00	-15.00% ▼
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	132.00	-14.84% ▼
Эрдэнэт авто зам	595.00	-14.39% ▼
Шивээ овоо	2,000.00	-13.04% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секьюритиз	363,035,380
Голомт капитал	237,405,858
Стандарт инвестмент	201,210,192
Ти Ди Би Капитал	170,214,938
БиДиСек	117,898,669

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	590.41	628,303
Таван толгой	7,665.00	403,679
Говь	33,960.00	264,926
МИК	11,200.00	231,944
Сүү	228.00	78,432

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудад нээлттэй өдөрлөг зохион байгуулагдана

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагууд, “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай хамтран “Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг”-ийг 2018 оны 6 дугаар сард Булган, Дархан-Уул, Орхон аймгуудад амжилттай зохион байгуулсан билээ.

Орон нутгийн дараагийн өдөрлөгийг Увс аймагт 2018 оны 10 дугаар сарын 24, 25-нд, Баян-Өлгий аймагт 27-ны өдөр, Ховд аймагт 29, 30-ны өдрүүдэд Аймгийн ЗДТГ-ын байранд тус тус зохион байгуулж, хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулахаас гадна “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх тул нутгийн иргэдийг өргөнөөр оролцохыг урьж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

МХБ: Үүргийн хэрэгжилт хангалтгүй хувьцаат компаниудыг бүртгэлээс хасна

Монголын Хөрөнгийн биржид 200 гаруй компани бүртгэлтэй байгаагаас 60 орчим хувийнх нь хөрвөх чадвар хангалтгүй, 95 компанийн үүргийн хэрэгжилт дутуу, 32 компанийн арилжаа нь зогсоод байгаа талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Эдгээр хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж, арилжиж байгаа бүтээгдэхүүнийх нь чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын төлөвлөгөө баталжээ. Энэ хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг 2019 оныг дуустал хийж, биржийн бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авахаар болоод байгаа юм. Сүүлийн нэг жилийн хугацаанд Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж хөрөнгийн захад шинээр гараад байгаа компаниуд санхүү болон үйл ажиллагааныхаа тайланг тогтмол ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа зохих хугацаанд хийж байгаа аж.

Харин өмч хувьчлалаар Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж байсан компаниудын тодорхой хэсэг нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээлж байна. Эдгээр компаниуд хувьцааныхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангаснаар хувьцаат компани хэвээр үлдэх боломжтой, эсвэл компанийн хэлбэрийг өөрчилж Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болох боломжтой юм.

Өмнөх жишээнүүдийг харвал “Жинст Увс” компанийн хувьцаа 1999-2016 онд 40 хүрэхгүй удаа арилжиж, 53 сая төгрөгийн хувьцааны арилжаа хийж байсан байна. Харин 2017 оны эцэст “Хөрөнгө оруулагч үндэстэн” хаалттай ХК-тай нэгдсэнээр арилжааны идэвх нь нэмэгдэж, хувьцааны ханш нь өсчээ. Мөн “Хөвсгөл Алтан дуулга” компани нэмж хувьцаа гарган зах зээлийн үнэлгээгээ бодит түвшинд хүргэснээр хувьцааны хөрвөх чадвар нь нэмэгдээд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хөгжлийн банк: 500 сая ам.долларын бондын санхүүжилт орж ирсэн

Энэ сард олон улсын зах зээлд арилжаалсан 500 сая ам.долларын бондын санхүүжилт орж ирсэн гэж Хөгжлийн банк мэдээллээ.

Таван жилийн хугацаатай, 7.25 хувийн купонтой энэхүү бондыг гаргасан нь дотоодын валютын захад үүсээд буй хэлбэлзлийг сааруулахад эергээр нөлөөлсөн гэж тус банк үзэж байна. Засгийн газрын баталгаагүй энэхүү бондын санхүүжилтээр богино хугацаатай эх үүсвэрүүдээ дахин санхүүжүүлнэ гэж Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал мэдээллээ. Тухайлбал, Хөгжлийн банкны хувьд 0-6 сарын хугацаатай эх үүсвэрийн өртөг 7.41 хувь болсон байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк цаашид бодлогын хүүгээ өсгөхийн хэрээр эх үүсвэрийн өртөг нэмэгдэнэ. Тиймээс одоогийнхоос бага өртөгтэй эх үүсвэр бүрдүүлэхэд анхаарч ажилласан гэж мэдээллээ.

Цаашид дунд хугацаандаа бонд гаргахаас гадна ногоон эх үүсвэрээс санхүүжилт татах бололцоотой. Тухайлбал, Ногоон бонд гаргаж, илүү урт хугацаатай, хүү багатай санхүүжилт татсанаар гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулж, агаарын бохирдлыг бууруулах боломжтой гэж Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЛэндМН: “Viber” ашиглан “Лэнд хэтэвч”-ээр мөнгө шилжүүлж болно

2018 оны эхний хоёр улирлын байдлаар мобайл банк буюу гар утсанд зориулсан банкны үйлчилгээ ашиглагчдын тоо давхардсан тоогоор 3.5 сая хүрсэн тухай Монголбанк мэдээллээ. Нийт 12.2 сая удаагийн цахим гүйлгээ хийгдэж, 2.3 их наяд төгрөг солилцсон байна. Төлбөр тооцооны гүйлгээ картын хэрэглээнээс цахим үйлчилгээ рүү шилжиж байгааг Төв банкныхан онцолж байгаа юм.

Хамгийн сүүлд “ЛэндмнББСБ” ХК цахим төлбөр тооцооны “Лэнд хэтэвч” үйлчилгээгээ танилцууллаа. Энэхүү бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрснээр гар утсаараа өдөр тутмын хэрэглээний төлбөр төлөх, хувь хүмүүс хоорондоо шимтгэлгүй мөнгө шилжүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм байна. Үүнээс гадна “Viber” аппликэйшн ашиглан мөнгө шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн талаар тус компани мэдээллээ. Цаашид “Facebook Messenger”-т “ЛэндМН”-ийн функцийг нэмэхээр төлөвлөжээ.

“Лэндмн ББСБ” ХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг харвал зээлийн орлогын хэмжээ нь III улиралд өмнөх улирлаас 19.4 хувиар өсөж, нийт нэг тэрбум 895.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Тус компани өнгөрсөн улиралд 763.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан талаар мэдээлсэн юм. Харин нийт активын хэмжээ нь өмнөх улирлаас 2.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

Үүнээс өмнө “Optimal Investment” компани онлайнээр зээлийн үйлчилгээ авах “Zeely” аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлсэн талаар мэдээлж байсан юм.

НҮБ-ын Олон улсын худалдаа, хөгжлийн байгууллагын тооцоолсноор ирэх он гэхэд мобайл, онлайн төлбөр тооцооны үйлчилгээ уламжлалт буюу банкны зээлийн болон дебит картын хэрэглээг давах төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Aspire Mining: Хөгжиж байгаа зах зээлийн металлургийн нүүрсний эрэлт нэмэгдэх төлөвтэй байна

Япон, БНСУ-ын металлургийн нүүрсний эрэлт тогтвортой байх боловч хөгжиж байгаа зах зээлүүдийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна гэж "Aspire Mining" компани таамаглаж байна. Мөн нүүрсний ханш өссөн нь нэгдэн, нийлэх хэлцлийн үйл явцад дэмжлэг болсон гэж тус компанийн удирдлагууд үзжээ. Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Aspire Mining" компани Овоотын нүүрсний төслийн эхний шатны хөгжүүлэлтийн Техник эдийн засгийн үндэслэлийг 2019 оны эхний хагаст танилцуулах товтой байна. Хэрэв холбогдох зөвшөөрлүүд гарвал эхний шатны хөгжүүлэлтийг 12-15 сарын хугацаанд дуусгах боломжтой гэж тус компани тооцоолж байна.

Сүүлийн арилжаагаар "Aspire Mining"-ийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржид 4.76 хувиар унаж, 0.02 австрали долларт хүрч хаагдсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Гашуунсухайт авто зам ХХК: Даваа гарагт Гашуунсухайт боомтоор нүүрсний 1,143 автомашин гарлаа

2018 оны эхний гурван улиралд Гашуунсухайт-Ганцмодны боомтоор Монголоос БНХАУ руу 13.3 сая орчим тонн коксжих нүүрс гаргасан талаар "Sxcoal.com" мэдээллээ. Гашуунсухайт-Ганцмод боомтоор нүүрс тээвэрлэн гарах автомашины тоо есдүгээр сараас хойш нэмэгдэж, хамгийн сүүлд даваа гарагийн байдлаар 1,143 автомашин гарсан талаар "Гашуунсухайт авто зам" ХХК мэдээллээ. Монгол Улсын хувьд оны эхний есөн сард 27 сая тонн нүүрс экспортолсон нь жилийн өмнөхөөс зургаан хувиар өссөн дүн болж байна. Мөн нэг тонн нүүрсний дундаж ханш 16 хувиар өсч, 78.5 ам.доллар болсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолно гэж Сангийн яам 2019 оны төсвийн төсөлдөө тусгасан байна. Гаалийн хяналтын шинэчлэлийг хийснээр экспортоо нэмэх боломжтой гэж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар үзэж байгаа юм. Одоогоор зургаан боомтын нэвтрэх чадвар, хяналтыг сайжруулж байгаа ажээ..

Эх сурвалж: BloombergTv.mn

ЗГ: Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлд төмөр зам тавибал нүүрсний экспорт нэмэгдэнэ

Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн төмөр замыг нарийн царигтай барихаар шийдвэрлэснийг Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замтай хамтад нь барих нь зүйтэй гэж Засгийн газар үзлээ.

Ингэснээр нүүрсний экспорт жилд 18-20 сая тонн хүртэл нэмэгдэнэ гэсэн тооцоо гарсан байна. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлд төмөр замтай болсноор нүүрсний экспорт болон боомтын нэвтрүүлэх хүчин чадал гурав дахин нэмэгдэж, тээврийн өртөг 2-4 дахин буурч, байгаль орчин, экологид учрах сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон давуу талтай ажээ.

Мөн ирэх онд газрын тосны бүтээгдэхүүний 30 хоногийн компанийн нөөц бүрдүүлэх 26 аж ахуйн нэгж, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг хавсралтаар баталлаа. Энэ дагуу ирэх жил аж ахуйн нэгжүүд 116,550.0 тонн шатахууны нөөц бүрдүүлэх юм байна. Өнгөрсөн онд нэр бүхий 21 аж ахуйн нэгж газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 94 мянга 700 тонноос доошгүй хэмжээнд байлгаж, тогтвортой хангажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Алт худалдан авах Монголбанкны үнэ нэмэгджээ

Монголбанк энэ оны 9-р сард 2,122.8 кг алт худалдан аваад байна.

Ингэснээр энэ оны эхний 9 сарын байдлаар нийтдээ 14,329 тонн алт худалдан авсан дүнтэй байна. Энэ оны 9-р сарын эхэн үед нэг грамм алт худалдан авах үнэ 95,446 төгрөг байсан бол одоо нэмэгдэж 101,061 төгрөг болоод байна.

УУХҮЯ-ны мэдээгээр алтны нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд алтны 41 шороон ордын 4,521.6 кг нөөц, 5 үндсэн ордын 18,697.9 кг нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн тус тус хүлээн авч Монгол Улсын алтны нөөцийг 23.2 тонноор нэмэгдүүлээд байна.

Эх сурвалж: Montsame.mn



ХХААХҮЯ: Үр тарианы 87.4 хувь, төмс, хүнсний ногооны 99.9 хувь, тэжээлийн 80.6 хувийг хураан аваад байна

Аравдугаар сарын 26-ны байдлаар 403 мянган тонн үр тариа, үүнээс 386.6 мянган тонн улаанбуудай, 254.3 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан аваад байна гэж ХХААХҮЯ мэдээллээ.

Энэ нь үр тарианы 87.4 хувь, төмс, хүнсний ногооны 99.9 хувь, тэжээлийн 80.6 хувийг хураан аваад байгаа үзүүлэлт болж байгаа юм. Үр тарианы хувьд гурав хоногийн өмнөхөөс 30 орчим тонноор өссөн байна. Ингэснээр улсын хэмжээнд ургац хураалтын ажил дунджаар 85.1 хувьтай байгаа юм. Шинэ ургацаас гурилын үйлдвэрүүд 135 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих сан 45 мянган тонн, нийт 180 мянган тонн хүнсний буудай борлуулсан тухай мэдээллээ.

Мөн ургац хураалтын ажилтай эзрэгцүүлж чанар сайтай сортын үрийн нөөц бүрдүүлэхээр ажиллаж байгаа талаар салбарын яам мэдээлсэн юм. Цаашид шинэ ургацаас хүнсний буудай худалдан авсан гурилын үйлдвэрүүдийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ХХААХҮЯ: Тэжээл бэлтгэл 80.6 хувьтай байна

Тэжээл бэлтгэл X сарын 23-ны байдлаар 80.6 хувьтай байна. Тодруулбал, 1 сая тонн өвс, 42.1 мянган тонн ногоон тэжээл, 62.9 мянган тонн давс, хужир, шүү бэлтгээд байгаа талаар ХХААХҮЯ мэдээллээ. Бэлтгэсэн хадлан 100 мянган тонноор, харин тэжээлийн хэмжээ өмнөх жилийн мөн үеэс 20 мянган тонноор өсөөд байна. Мөн ургацын урьдчилсан балансаар 86.3 мянган тонн ногоон тэжээл, гурилын үйлдвэрүүдээс 100-аад мянган тонн тэжээл үйлдвэрлэхээр тооцоо гарсан нь тэжээлийн хангамж хүрэлцэхүйц байна гэж мэдээлсэн юм. VII-IX сард орсон хур тунадаснаас шалтгаалж 80 орчим мянган га талбай эрсдэлд орсон. Үүнээс 30 орчим мянган га нь ногоон тэжээл рүү шилжсэн байна. 250 аж ахуйн нэгжид 4.62-5.5 хувийн хүүтэй зээл олгосноос дийлэнх нь хөдөө аж ахуйн компаниуд байсан гэж Хөгжлийн банкны "Ди Би Эм Лизинг" компанийн Гүйцэтгэх захирал О.Гэрэлмаа онцоллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

World Economics: Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс дөрвөн сар дараалан буурлаа

Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс аравдугаар сард үргэлжлэн унаж, 56.3 нэгж болсон талаар "World Economics" байгууллага мэдээллээ.

Он гарснаас хойш зургаан сар дараалан өсөөд байсан энэхүү индекс сүүлийн дөрвөн сарын турш унахад бизнесийн итгэл буурсан нь голлон нөлөөлсөн гэж тус байгууллага үзсэн байна. Юанийн ханш энэ онд төгрөгийн эсрэг чангарч, сүүлийн 10 жил гаруйн дээд түвшинд хүрээд байгаа юм. Энэ нь бизнес эрхлэгчдэд хүнд дарамт болсныг тайландаа онцолсон байна. Өөрөөр хэлбэл бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа нь энэхүү индекст сөргөөр нөлөөлжээ. БНХАУ-ын эдийн засаг худалдааны маргаанаас үүдэн удааширсан нь Монгол Улсын эдийн засагт нөлөөлж байгааг мэдээллээ. Нөгөө талаас Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс 50 нэгжээс дээш буюу өсөлтийн бүсэд хадгалагдаж байгааг онцлов.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголбанк: Зээлийн дундаж хүү сүүлийн нэг жилд 2.3 нэгж хувиар буурсан

Шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн дүнгээр 2.3 нэгж хувиар буурч, есдүгээр сарын байдлаар 17.7 хувь болсон гэж Монголбанк мэдээллээ. Тайлант хугацаанд шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.3 нэгж хувиар буурч, есдүгээр сарын байдлаар 11.4 хувь болоод байна.

Зээлийн хүүний статистикаас харахад бизнесийн зээлийн хүү дунджаас бага буюу 17.1 хувь байгаа юм. Өнгөрсөн гурван сард хэрэглээний зээлийн эрэлт бизнесийнхээс өндөр байжээ. Ирэх гурван сард банкууд хэрэглээ, бизнесийн зээлийн эрэлтийн өсөлт удааширна гэсэн хүлээлттэй байгааг Монголбанк мэдээллээ. Бүтцээр нь авч үзвэл нийт зээлийн үлдэгдлийн тал хувийг бизнесийн зээл эзэлж байна. Бизнесийн зээл өмнөх оны мөн үеэс 19 хувиар өссөн бол хэрэглээний зээл илүү хурдацтай буюу 24 хувиар өсчээ.

Харин есдүгээр сард хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 27 тэрбум төгрөг буюу гурван хувиар, чанаргүй зээл өмнөх сараас найман тэрбум төгрөг буюу нэг хувиар буурсан байна. Хэдий тийм боловч чанаргүй зээл нийт зээлийн үлдэгдлийн 8.3 хувийг эзэлж байгаа нь зохистой түвшнээс өндөр гэж Монголбанк үзжээ. Тиймээс 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд чанаргүй активыг бууруулах стратеги хэрэгжүүлэхээр тусгаад байна. Боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилгын салбар чанаргүй зээлийн 50 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байгааг Төв банк мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

2019 оны төсвийн орлогыг өөдрөгөөр тооцсон гэх шүүмжлэл шинжээчдийн дунд давамгайлж байна

2019 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого энэ оны батлагдсан түвшнээс 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдээд байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 88.7 хувийг татварын орлого бүрдүүлэхээр Сангийн яам тооцжээ.

Харин татварын орлогын 27 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 23.5 хувийг орлогын албан татвар бүрдүүлэхээр тооцсон байна. Төсвийн орлого хэт өөдрөг байна гэсэн шүүмжлэл "Bloomberg"-ийн Эдийн засагчдын клубийн зарим шинжээчдийн дунд давамгайлж байгаа юм.

Мөн эдийн засгийн өсөлт найман хувьд байхаар төсөөлсөн нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Монголбанкны дунджаас хоёр пунктээр өндөр байгааг онцолж байгаа юм. Төсвийн орлого биелэхгүй байх эрсдэлийг зэс, нүүрсний үнийн хэлбэлзэл, хил гаалийн нэвтрүүлэх чадвар, ААНОАТ-ын орлогыг хэт нэмэгдүүлж тооцсон гэж эдийн засагчид тодорхойлжээ.

Төсвийн уул уурхайгаас хамаарах хамаарал улам бүр нэмэгдэж байгаа нь эдийн засгийн төрөлжилтийн бодлого хэрэгжихгүй байгааг харуулж байна гэж зарим судлаачид үзэж байна. Ирэх оны төсвийн орлогын 30 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлэхээр тооцсон байна. Тухайлбал, 42 сая тонн нүүрс, 1.4 сая тонн зэсээс ойролцоогоор гурван их наяд төгрөгийн орлого бүрдүүлэхээр төсвийн төсөлд тусгажээ. Сангийн сайд энэ талаар "Ашигт малтмал экспортолж буй зургаан боомтын хяналтыг сайжруулах арга хэмжээ авна. Хилээр гарч байгаа баялгаа бүрэн хэмжээгээр тооцдог болох зорилгоор гаалийн шинэчлэл эхлүүлнэ. Рентген байршуулж, автомашин бүрээс сорьц авдаг болно" гэж мэдэгдэж байсан юм. Мөн Татварын багц хуулийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэх товтой байна. Хуулийн шинэчлэлээр татварын бааз суурь нэмэгдэж, төсвийн орлогын бүрдэлтэд эергээр нөлөөлнө гэж Сангийн яам тооцжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

WIF: Олон улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 онд 23 хувиар буурсан

Дэлхийн хөрөнгө оруулалтын форум Швейцарын Женев хотноо эхлээд байна. Олон улсын хэмжээнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал 2017 онд 23 хувиар буурсан бөгөөд энэ нь дэлхийн улс орнуудын бодлого төлөвлөгчдөд, ялангуяа хөгжиж буй орнуудад урт хугацааны сорилт бий болгож байгааг шинжээчид онцолжээ. 22-26-ны өдрүүдэд болох энэхүү форум нь тулгарсан асуудлуудыг нээлттэй хэлэлцэж, шинэ санаачилга, шийдлүүдийг гаргах зорилготой юм. Форумд 14 улсын Засгийн газар болон Төрийн тэргүүн нараас гадна Баялгийн сангууд түүнчлэн "Aviva", "De Beers", "Coca Cola" зэрэг үндэстэн дамнасан 30 гаруй компанийн удирдлага оролцож байна. НҮБ-ын мэдээлснээр хөгжиж буй орнуудын хувийн салбарын хөрөнгө оруулалт жилийн 3.9 их наяд ам.доллараар хэмжигдэж байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.